



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 18 өдөр

Дугаар А/384

Арвайхээр

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх журам батлах тухай” 25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгууллагын санал хүсэлтийн дагуу Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэлтэй Мал эмнэлгийн үржлийн тасгийн 2011 онд үйлдвэрлэгдсэн, 2012 онд ашиглалтад орсон 19,990,000 (арван есөн сая есөн зуун ерэн мянга) төгрөгийн балансын үнэтэй, 880,236.72 (найман зуун наян мянга хоёр зуун гучин зургаан төгрөг далан хоёр мөнгө) төгрөгийн үлдэх өртөгтэй, УАЗ-3909 фермер маркийн 44-57 ӨВР улсын дугаартай автомашины дуудлага худалдааг зохион байгуулах эрхийг Гучин-Ус сумын Засаг даргын Тамгын газарт олгосугай.

2. Дуудлага худалдаанаас олсон орлогыг Гучин-Ус сумын Мал эмнэлгийн үржлийн тасагт шинэ автомашин худалдан авахад зарцуулсугай.

3. Худалдах хөрөнгөнд мэргэжилийн байгууллагаар үнэлгээ тогтоолгож, хөрөнгийн дуудлага худалдааг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, дуудлага худалдааны материалыг Орон нутгийн өмчийн газарт ирүүлэхийг Гучин-Ус сумын Засаг дарга (Х.Энхтайван)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг (З.Балданням)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100820

D:My Doc. Zahiramj. Zasaag darga